



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн, нийт 34,154,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун тавин дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ч.Амгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137004564
7-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 03 дугаар сарын 16 ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

БУЛГАН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Автомашини нэр, төрөл, марк, улсын болон арлын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ /төгрөг/
1	Суудлын автомашин УАЗ-469, Улсын дугаар 65-59 БУА, Арлын дугаар 000100450537948	2006	2006	12,654,000.00	2,100,000.00
2	Суудлын автомашин Ланд круйзер-80, Улсын дугаар 00-24 БУА, Арлын дугаар FZJ8000118142	1995	1995	21,500,000.00	3,300,000.00
Нийт дүн:				34,154,000.00	5,400,000.00
				(гучин дөрвөн сая нэг зуун тавин дөрвөн мянган төгрөг)	(таван сая дөрвөн зуун мянган төгрөг)